



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.1.5, 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Журам батлах тухай” Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7 дахь заалтын “... 10 дугаар сарын 15-наас ...” гэснийг “...09 дүгээр сарын 10-наас ...” гэж өөрчилсүгэй.

2. Тушаалыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ойн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Тунгалаг, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Батсансар нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Архангай, Баян-Өлгий, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Төв, Завхан, Хөвсгөл, Увс, Хэнтий аймгийн болон Нийслэлийн Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

САЙД

Д.ОЮУНХОРОЛ

